

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ
ШИНЖЛЭХ УХААНЫ СУРГУУЛЬ
эрдэм шинжилгээний бичиг

Боть XXXIX (433)

2015

(63-72)

МОНГОЛ, АНГЛИ ХЭЛНИЙ АВИА ДУУРАЙХ ҮГ

Б. Нямжав^{*}, Ж. Цэрэндэжид^{}**

Байгаль, амьтны хийгээд ахуй амьдрал дээр үүсэх аливаа дуу чимээ, дуу авиа нь ямар ч хүний чихнээ нэг л ижил сонсогдоно. Аливаа үндэстний хэлэнд уг дуу авиаг дүрслэн нэрлэсэн авиа дуурайх үг гэж байх боловч хэл хэлэнд харилцан адилгүй байгаа нь сонирхолтой юм. Гиймээс нүүдлийн соёл иргэншилтэй монгол түмний хэл болон суурьшмал соёл иргэншилтэй англи түмний хэлэнд авиа дуурайх үгс хэрхэн илэрч буйг зэрэгцүүлэн үзэхийг зорилоо.

Хүн бодит ертөнцийн юмсын дүр байдлыг нүдээрээ, дуу авиаг чихээрээ хүртэж уг зүйлийг таньж ухааран, өөрийн хэлэндээ тэр хэвээр нь тусгадаг. Үүнд дүрслэх үг хамаатай бөгөөд дүрслэх үгийг дотор нь дүрс дуурайх үг, авиа дуурайх үг гэж хоёр ялгадаг. Бодвол дүр байдал заасан үг ба авиа дуурайх үг нь өөр өөр хэл соёлтой хүмүүсийн нүд чихнээ ижил хүртэн сонсогдох учир аливаа хэлний дүрс ба авиа дуурайх үгс хоорондоо ижил төстэй байна. Гэтэл энэ нь хэл хэлэнд өөр байдаг бөгөөд цөөн тохиолдол л ижил төстэй байдлаар илэрсэн байдаг нь сонин үзэгдэл юм.

Монгол хэлний авиа дуурайх үгийг Ш.Лувсанвандан, Ш.Барайшир, П.Бямбасан, Ц.Өнөрбаян нарын эрдэмтэд өөрийн зохиол бүтээлдээ хэл шинжлэлийн бусад асуудлыг хөндөх явцдаа товч авч үзсэн байх бөгөөд Ц.Б.Цыдендамбаев, Л.Ш.Шагдаров, М.Базаррагчаа, Е.В.Сундуева нар тухайлан судалжээ. Тухайлбал, буриад хэлний авиа дуурайх үгийг Ц.Б.Цыдендамбаев, Л.Ш.Шагдаров нар, казах хэлнийхийг А.И.Искаков, якут хэлнийхийг Л.Н.Харитов тус тус судалжээ. Үүнээс гадна, Д.Сайнбилэг “Солонгос, монгол хэлний дуурайх үгийг харьцуулсан нь”, А.Мөнхзул “Авиа дуурайх үг”, М.Энхтуяа “Франц-Монгол хэлний авиа дуурайх үгийн зэрэгцүүлэл” гэх мэт сэдвээр тус тус магистрын зэрэг горилох нэг сэдэвт зохиол бичсэнийг монгол хэлний авиа дуурайх үгийг гадаад хэлтэй харьцуулах болон зэрэгцүүлэн судлах эхлэл болжээ гэж үзэж болох боловч англи хэлтэй зэрэгцүүлэн үзсэн судалгаа одоогийн байдлаар огт байхгүй байна.

Монгол хэлний авиа дуурайх үгийг эрдэмтэд хэрхэн тодорхойлсныг авч үзвэл, Ш.Лувсанвандан, “Дуу чимээний үгс гэдэг нь үнэндээ чихэнд сонсох дуу чимээг ч дүрслэн үзүүлэх үгсгээр хязгаарлагдахгүй, мөн нүдэнд харагдах, биед хүртэх янз бүрийн

^{*} МУИС, Шинжлэх ухааны сургууль, Их Британи Судлалын тэнхим

^{**} МУИС, Шинжлэх ухааны сургууль, Гадаад хэлний төв

үйл хөдөлгөөний янз бүрийн байдлыг дүрслэн үзүүлэх бүлэг үгс юм” гээд үүнийг аялга үгтэй хутгаж болохгүй гэжээ.¹

Ш.Барайшир, “... тас няс, сэр сэр, гялс гялс, түг түг, наг наг, бөн бөн зэргийг дүрслэх дайвар үг гээд эдгээр нь үйл байдлын дуу чимээ, хөдөлгөөн зэргийн нүдэнд үзэгдэх, чихэнд сонсох сэтгэл санаанд сэр хийтэл дүрслэн гаргадаг үгс юм”² гэсэн байхад П.Бямбасан “Үйл үгийн зарим язгуур”³, “Орчин цагийн монгол хэлний үйл үгийн идэвхгүй язгуурын тухай зарим ажиглалт”⁴, “Үйл үг бүтээх дагаврууд”⁵ гэх мэт өгүүлэлдээ авиа дуурайсан язгуур үгэнд үйл үг бүтээх дагавар залган үг бүтээх болон монгол хэлний авиа дуурайх үгс гэгдэх язгууртай үйл үгийн өмнө тохиолдох онцлог зэргийг авч үзжээ. Ц.Өнөрбаян авиа дуурайх үгийг үг зүйн түвшинд судлан, “-хий, -ги, -гина, -хир, -жигна, -ш, -л, -р, -тна зэрэг дуу авиа дуурайх язгуураас үйл үг бүтээх дагавар байдаг”⁶ гэж дурдсан байна. М.Базаррагчаа авиа дуурайх үгсээс авиа сэлгэн шинэ үг бүтэх ёсыг хангалттай жишээ баримтаар дэлгэрэнгүй тайлбарласан бөгөөд “Монгол хэлний авиа сэлгэх ёс” хэмээх бүтээлдээ, “Эрдэмтэн Т.А.Бертагаев, ‘Адгуусан амьтнаас ялгараагүй байсан хүний өвөг дээдсийн хашхирах дохио нь газар нутгийн хувьд ялгаран хувирсаар ирсэн ба энэ нь хэлнүүдийн ялгарах эхлэл болжээ’ гэж хүний хэлний анхны эх үүсвэрийн тухай өгүүлсэн байдаг. Энэ үед хүмүүс байгалийн авиаг дуурайсан үг-өгүүлбэр, эсвэл юм үзэгдэлд хэрхэн хандах хандлагаа илэрхийлсэн аялга үг-өгүүлбэр хэлдэг байсан биз гэж бодогдож байна. Жишээлбэл, салхи шуугих дуу чимээ дуурайн *шуугих, сүүгэх, шуухирах, шуухитнах, шуур шуур дуутай* гэх мэт үгс үүссэн бөгөөд *дуу шуу, шуурга, шуурах, шуурхай* зэрэг утга нэлээд шилжсэн үг үүсжээ” гээд “Монгол хэлний дүрслэх үг нь нүдтэй, авиа дуурайх үг нь чихтэй тус тус холбогдох ба нүднээ үзэгдэх дүрслэлээс үүдэн аманд мэдрэгдэх *дарвигнах* гэх мэт үг дам үүсжээ. Мөн чихнээ сонсох авиа дуурайх үгсээс хамарт мэдрэгдэх *сэнгэнэх, ханхлах* гэх мэт цөөн үгс үүссэн байна”⁷ гэжээ. Мөн “Монгол хэлний авиа дуурайх үг нь үйл үгийн өмнө тодотгох утгатай тэг үндсээр хамжин орж үйлийн тодотгол гишүүн болох тул үл хувилах үгсийн аймгийн нэг бүрэлдэхүүн болох үгс юм”⁸ гэж М.Базаррагчаа үзсэн байна.

Англи хэлэнд авиа дуурайх үгийг “*Onomatopoeia*” гэх бөгөөд уг үг нь Герег хэлний “*onomata*” буюу “нэр”, “*poiein*” буюу “хийх” гэсэн хоёр үгээс үүссэн “нэрлэх” гэсэн утгатай үг юм. Уг нэр томъёо нь англи хэлэнд 16-р зууны сүүл үед герег хэлнээс латин хэлээр дамжин орж иржээ. Англи хэлний авиа дуурайх үгийг хэл шинжлэлийн үүднээс судалсан судалгаа ховор байгаа хэдий ч ямар нэг талаар өөр хэлний авиа дуурайх үгтэй харьцуулсан, зэрэгцүүлсэн судалгаа, өгүүлэл цөөнгүй байна. Жишээлбэл, Хайтам К. Ал-Зуббайди “Орчин цагийн англи, араб яруу найраг дахь авиа дуурайх үгсийн үүрэг” гэсэн өгүүлэлдээ англи, араб уран зохиол, яруу найрагт гарч байгаа авиа дуурайх үгийг үгийн сан, утга зүй, үүргийн талаас нь судлан тайлбарласан байхад Мартин Фликсэ

¹) Лувсанвандан Ш. (1989), Монгол хэл шинжлэлийн асуудлууд. Улаанбаатар, 274-275-р тал.

²) Барайшир Ш. (1970), Орчин цагийн монгол хэлний дайвар үг. Улаанбаатар, 50-52-р тал.

³) Бямбасан П. (2006), Монгол хэлний онол, бүтцийн асуудалд. Улаанбаатар, 64-68-р тал.

⁴) Бямбасан П. (Дурдсан зохиол), 69-85-р тал.

⁵) Бямбасан П. (Дурдсан зохиол), 94-98-р тал.

⁶) Өнөрбаян Ц. (1998), Орчин цагийн монгол хэлний үг зүй. Улаанбаатар, 43-44-р тал.

⁷) Базаррагчаа М. (1987), Монгол хэлний авиа сэлгэх ёс. Улаанбаатар, 98-р тал.

⁸) Базаррагчаа М. (2005), Монгол хэлний өгүүлбэр судлал. Улаанбаатар, 209-215-р тал.

“Япон хэлний авиа дуурайх үгийг Швед хэлнээ орчуулах нь” гэсэн өгүүлэлдээ тус хоёр хэлний авиа дуурайх үгсийн хэлбэр хийгээд үгийн санжих зэргийг тайлбарласан байна.

Ертөнцийн түг түмэн юмс үзэгдэл бүрээс гарах дуу авиа, анир чимээ өөр өөрөөр сонсдох боловч хэлэнд түүнийг ерөнхийлөн дуурайж буулгадаг. Монгол хэл олон янзын дуу авиаг ялгасан язгуур үгээр маш баян бөгөөд авиа чөлөөтэй сэлгэснээр утга ялган заадаг онцлогтой. Жишээлбэл, *тас* гэдэг үгний *t* авиа нь эрчимтэй, хүчтэй чанга дуу авианы утга, *a* авиа нь том сүрлэг, цул хөндий зүйлээс төрөх ил задгай, чанга, ойрын дуу авианы утга, *c* нь гэнэтийн огцом хүчний нөлөөгөөр ямар нэг хатуу зүйлийн хагарч тасрах, цоорч задрах, тэсэрч цацрах үйл хөдлөлөөс гарах дуу чимээний утгыг тус тус илэрхийлж байна.

Буриадын эрдэмтэн Ц.Б.Цыдендамбаев буриад хэлний дүрслэх үгийг а) хөдөлгөөн заасан, б) авиа дуурайсан гэж хоёр ангилаад, авиа дүрслэх үг нь –б: тоб-тоб, -г: пиг пиг, -д,с: лад, лас, -л: шол шол, -н: хан ян, -р: хар-хар зэрэг гийгүүлэгчээр төгсөж, эцсийн гийгүүлэгч нь утга ялгах үүрэгтэй гэжээ. Жишээ нь: “шаб шаб, шаг шаг, шад шад, шар шар, шал шал” гэвэл эцсийн гийгүүлэгч нь янз бүрийн дуу чимээг дуурайн, ялгаж байна. ... Мөн авиа дүрсэлсэн (дуурайсан) үгсийн эгшиг, гийгүүлэгч сэлгэж олон үг үүсгэхээс гадна, давтах хорших аргаар шинэ үг үүснэ гэжээ.⁹

Дээрхээс үзвэл, монгол хэлэнд авиа дуурайх үгс нь голчлон авиа сэлгэх, язгуур давтах, язгуур хорших гэх мэт аргаар үүсдэг байна. Харин монгол, англи хэлний авиа дуурайх үгийг зэрэгцүүлэн үзэхийн тулд тодорхой ангилан авч үзэх нь зөв юм. Тиймээс эрдэмтэд үүнийг хэрхэн ангилсныг авч үзвэл, М.Базаррагчаа монгол хэлний авиа дуурайх язгуур үгсийг ‘н төгсгөлтэй авиа дуурайх үг’, ‘г төгсгөлтэй авиа дуурайх үг’ гэх мэтээр төгсгөлийн авиагаар нь 8 ангилан, тус бүрт хамаарах эгшиг авианы сэлгэцээр үүссэн үгс болон авиа дуурайх үгээс үүссэн болох нь сайн ялгарахаа больсон үгсийг дор бүр нь авч үзжээ. Эрдэмтэн Д.А.Абашеев, У.Ш.Дондуков нар авиа дуурайх үгийг 1. гэрийн амьтны дуу; 2. амьтан болоод шувууны дуу; 3. хүний үйлдлийн үр дүнд гарах дуу; 4. хүний дуу¹⁰ гэж 4 ангилсан байхад А.В. Филипов орос хэлний авиа дуурайх үгийг 1. шувуудын дуу; 2. амьтдын дуу; 3. амьгүй юмын хөдөлгөөнөөс гарах дуу; 4. хөгжмийн зэмсгийн дуу; 5. хүний утгагүй дуу; 6. хүний дуурайж хэлэх дуу; 7. янз бүрийн дуу гэж ангилсан байна.¹¹ Олон улсын монголч эрдэмтдийн хоёрдугаар их хуралд М.Халтод “Монгол хэлний үйл үгийн язгуур үндэс дэх авиа дуурайх авиа” хэмээх илтгэлдээ, монгол хэлний авиа дуурайх үгийг *хүний, малын, араатан амьтны, байгалийн үзэгдлийн, бодис юмны* гэх мэтээр ангилаад “Монгол үгийн үйл үгийн язгуур үндэс дэх авиа дуурайх авиа авианууд Э, ЭГ, ГЭ, ГЭГ гэх мэт нэг үеэр бүтжээ”¹² гэж үзсэн байна. (М.Базаррагчаа, “Монгол хэлний авиа сэлгэх ёс” номноос дам авав)

Харин англи хэлний авианы үгийг утгын холбоо бүхий шинжээр нь *хүний, амьтны, тээврийн хэрэгслийн, бусад*¹³ гэж ерөнхий ангилсан байдгаас гадна,

1. Устай холбоотой авиа дуурайх үг

⁹ Базаррагчаа М. (1987), Монгол хэлний авиа сэлгэх ёс. Улаанбаатар, 103-р тал.

¹⁰ Дондуков У. Ш., Абашеев Д. А. (1962), Грамматика бурятского языка, (Фонетика и морфология). Москва, 334-335-р тал.

¹¹ Базаррагчаа М. (1987), Монгол хэлний авиа сэлгэх ёс. Улаанбаатар, 91-р тал.

¹² Халтод М. (1973), Олон улсын монголч эрдэмтний II их хурал, II боть, Улаанбаатар, 196-р тал.

¹³ <http://www.noisehelp.com/examples-of-onomatopoeia.html>

2. Дуу хоолойтой холбоотой авиа дуурайх үг
3. Мөргөлдөхтэй холбоотой авиа дуурайх үг
4. Агаар болон хийтэй холбоотой авиа дуурайх үг
5. Амьтны дуу чимээ гэж бас ангилсан байдаг.¹⁴

Бид монгол, англи хэлний авиа дуурайх үгсийг зэрэгцүүлэн үзэхийн тулд дээрх ангиллуудыг үндэс болгон дараах байдлаар ангилах саналтай байна. Үүнд:

1. Ус буюу шингэн зүйлээс үүссэн авиа дуурайх үг
2. Агаар, хийтэй холбоотой болон тэсрэх, дэлбэрэхээс үүссэн авиа дуурайх үг
3. Хоёр биет мөргөлдөх, харшилдахаас үүссэн авиа дуурайх үг
4. Хүний дуу хоолой, үйл хөдлөлөөс үүссэн авиа дуурайх үг
5. Амьтны дуу чимээг дуурайсан авиа дуурайх үг
6. Ахуй амьдралд хэрэглэгдэх эд зүйлээс үүсэх дуу авиаг дуурайх үг

1. Ус буюу шингэн зүйлээс үүссэн авиа дуурайх үг

Монгол, англи хэлний ус буюу шингэн зүйлтэй холбоотой үүссэн авиа дуурайх үгсийг зэрэгцүүлэн үзвэл дараах байдалтай байна. **Монгол хэлний хувьд:**

- Усанд юм унах чимээг:
 - Пал (усанд том, хавтгай биет унахад гарах чимээ)
 - Пул (усанд томгүй хэмжээтэй, нягт хатуу биет унахад гарах чимээ)
 - Пүл (их хэмжээний гүн усанд нягт хатуу биет унахад гарах чимээ)
 - Шал/ шал пал (гүехэн усанд юм унах эсвэл устай шавартай газраар явахад гарах чимээ)
 - Шол (усанд жижиг биет унах эсвэл бага хэмжээний шингэн өндрөөс хийхэд гарах чимээ)
 - Пял (гүехэн усанд том биет эсвэл ахиухан нялцгай зуурмаг дусаахад гарах чимээ)
 - Цүл (их хэмжээний гүнзгий усанд хатуу биет ус цалгиулан унахад гарах чимээ)
 - Чол (усанд жижиг биет унахад гарах чимээ)
- Ус дуслах, асгах, гоожих, урсах чимээг:
 - Под (хатуу юман дээр ус дуслах чимээ)
 - Шол (усан дээр ус дуслах чимээ)
 - Шор шор (шингэн юм ихээр биш багаар гоожих, тэгш бус гадарга дээр урсах чимээ)
 - Пал (хатуу юман дээр эсвэл усан дээр ус хүчтэй асгах чимээ)
 - Хор хор (горхи урсах, хоржигнох чимээ)
 - Тог тог (цонхны шил юмуу дээвэр дээр бороо дуслах чимээ)
- Шингэн зүйл буцлах чимээг:
 - Пор пор, пур пур, бур бур
- Савтай шингэн зайлагдан цалгих, цацах чимээг:
 - Хол хол (саван дахь шингэн хүч багатай зайлагдах)
 - Цол цол, цул цул, цал пал (саван дахь шингэн хүчтэй зайлагдах) гэх мэтээр дуурайн тэмдэглэсэн байхад **англи хэлний хувьд:**

¹⁴⁾ <http://examples.yourdictionary.com/5-examples-of-onomatopoeia.html>

- Усанд юм унах чимээг:
 - Slump (усанд унах, живэхэд гарах чимээ)
 - Plop (хатуу биет ус ихээр цалгиулахгүйгээр усанд унах)
 - Squelch, squerch (усархаг эсвэл шавартай газраар явахад гарах чимээ)
 - Squish (усанд юм унах чимээ)
- Ус дуслах, асгах, гоожих, урсах чимээг:
 - dot a dot dot/ Flick a flack fleck / spack a speck speck (цонхны шилэн дээр бороо дуслах чимээ)
 - Plip plip ploop (дээвэр дээр бороо дуслах чимээ)
 - Tluck tlock (усны хаалтнаас ус дуслах чимээ)
 - Glop (өтгөвтөр шингэн зүйлийг хатуу юман дээр асгах дусаах чимээ)
 - Flush (ус хальж дүүрэн асгарах чимээ)
 - Spoot (ам дүүрэн шингэнийг нулмих, цацахад гарах чимээ)
- Шингэн зүйл буцлах чимээг:
 - Bubble bubble / blllgh bllllggggh bllllgggghh
- Савтай шингэн зайлагдан цалгих, цацах чимээг:
 - Slosh (ус цалгих, цацах, мөн ус туулахад гарах чимээ)
 - Splash / splosh / sploosh (ус цалгих, цацах чимээ)
 - Splatter (ус цацах, үсрэх, үсчих чимээ) гэх мэтээр дуурайн тэмдэглэсэн байна.

Үүнээс үзвэл, монгол хэлний ус болон шингэн зүйлээс үүссэн авиа дуурайх үгс усны хэмжээ, гүн гүехэн байдал, устай харьцаж байгаа биетийн шинж чанар, хэмжээ гэх мэтээс шалтгаалан “п, ш, ц, х, ч” гэх мэт авиагаар эхлэхийн зэрэгцээ нэг үеэс үүссэн язгуур үгэн дэх авиа сэлгэн нарийн утгыг ялган зааж байна. Мөн усанд юм унах болон дусахад, ус цалгихад үүсэх авиа дуурайх үгс “л” авиагаар, усны үргэлжлэн чичрэх, доргих хөдөлгөөнөөс үүсэх буюу буцлах хоржигнон урсахад гарах авиа дуурайх үгс “р” авиагаар төгссөн байна. Харин англи хэлний устай холбоотой авиа дуурайх үгс “сл-, пл-, тл-, гл-, фл-” болон “сп-, спл-, скв-” гэсэн нийлмэл авиагаар эхлээд “-п, -ш, -ч” гэх мэт авиагаар төгссөн байгаа нь ажиглагдаж байна. Хоёр хэлний устай холбоотой авиа дуурайх үгсийг зэрэгцүүлэн үзвэл нэг дуу чимээг ижилхэн нэрлэж хэлсэн тохиолдол байхгүй, өөр өөрөөр дуурайн нэрлэсэн байгаа хэдий ч уг авиа дуурайх үгсэд “л, п, ш, ч” гэх мэт ижилхэн авиа түгээмэл орсон байна.

2. Агаар, хийтэй холбоотой болон тэсрэх, дэлбэрэхээс үүссэн авиа дуурайх үг

Монгол, англи хэлний агаар, хий, хийн даралтаас үүсэн тэсрэх, хагарах, дэлбэрэхтэй холбоотой авиа дуурайх үгсийг зэрэгцүүлэн үзвэл дараах байдалтай байна. Үүнд:

- Дэлбэрэх тэсрэх чимээ:
 - Пан/пүн (хөндий юмны чанга дуугарах мөн хийн даралтаар юмыг савнаас шахаж гаргах чимээ)
 - Пас/пэс/пис (дотроо хөндий хийтэй юмны хагарах, дэлбэрэх чимээ)
 - Чад пад/шад пад (галд мод түлээ шатахад модон дахь хий нь агаарт тэсрэн гарах чимээ)
- Ямар нэг юм маш хурдтайгаар агаар зүсэн өнгөрөх, шунгинах чимээ:
 - Сун/сүн (машин, морь, хүн салхи зүсэн хурдтай давхиж өнгөрөх чимээ)
 - Шун (сум гэх мэт жижиг биет агаарыг хурдтай зүсэж өнгөрөх чимээ)

- Сэп/сүп (ямар нэг юмыг хурдан хөдөлгөх, хөдлөхөд гарах чимээ)
- Салхилахад үүсэх чимээ:
 - Сэр сэр (салхи салхилах чимээ)
 - Сар сар/сүр сар (салхилахад юм хөдлөх зэрэгт гарах чимээ) гэх мэт байна.
- Эдгээр нь англи хэлэнд хэрхэн илэрч буйг авч үзвэл,
 - Дэлбэрэх тэсрэх чимээ:
 - Badaboom/barroom/blam/blast/bomb/boom/bwoom/boosh/kaboom/kapow/sssshblam/wham/ whomp (дэлбэрэх, тэсрэхэд гарах чимээ)
 - P-taff (гар буугаар буудах чимээ)
 - Poomb (хуучны гар буун дуу)
 - Pop (хийтэй гялгар уут, үлээсэн бохь гэх мэт задрах, хагарах чимээ)
 - Splat (цахилгаан цахих чимээ)
 - Crackle (галд мод түлээ шатахад гарах чимээ)
 - Ямар нэг юм маш хурдтайгаар агаар зүсэн өнгөрөх, шунгинах чимээ:
 - Swish (ус агаарыг зүсэн өнгөрөх чимээ)
 - Varoom (салхи зүсэн хурдтай өнгөрөх машины чимээ)
 - Салхилахад үүсэх чимээ:
 - Swoosh (хүчтэй үлээх салхины чимээ)
 - Hoo hoo hoo hoo / yooooo (салхи салхилах чимээ) гэх мэт байна.

Монгол, англи хэлний тэсрэх, дэлбэрэх дуу авиаг дуурайсан үгсэд бүрэн болон хагас таарах үгс байхгүй байгаа хэдий ч ийм авиа дуурайх үгэнд ижил төстэй авианууд орсон байна. Тухайлбал, монгол хэлэнд тэсрэх дэлбэрэх дуу авиа “ш, п, ч” гэх мэт чанга дуутай, амьсгалын түрэлттэй, хамжин тэсрэх гэх мэт авиагаар эхлэн “с, д, н” гэх мэт үе төгсгөх гийгүүлэгчээр төгссөн нэг үетэй үгээр илэрч байхад англи хэлэнд голчлон “б, п, в”, цөөхөн тохиолдолд “сп, кр, к” гэх мэт авиагаар эхлээд “ш, м, б, п, т, р” гэх мэт авиагаар төгсч буйгаас үзвэл уг хоёр хэлний ийм авиа дуурайх үгэнд “п/б, ш/с, д/т” гэх мэт авиа түгээмэл орсон байна. Агаар салхи, усыг хурдтай сөрөн зүсч гарах авиа дуурайсан үгсийн хувьд хоёр хэлэнд мөн өөр өөрөөр илэрч байгаа хэдий ч исгэрэх уртгатай “с” авиа аль алинд нь орсон байгаагаараа төстэй байна. Үүнээс гадна англи хэлний салхины дуу чимээг дуурайсан үгс нь “үү” гэсэн урт эгшигтэй байна.

3. Мөргөлдөх, харшилдахаас үүссэн авиа дуурайх үг

- Хатуу биет өөр юмтай мөргөлдөх (унах, цохих, нүдэх, мөргөх гэх мэт):
 - тас/түс/тэс/няс (алгадах, хурц огцом цохих эсвэл шаазан, шил гэх мэт зүйл хагарах чимээ)
 - пад/пэд/пид (хатуувтар юмыг цохих, дэвсэх эсвэл жинтэй зөөлөвтөр юм унах чимээ)
 - под/пүд (хөнгөн юм унах эсвэл юмыг савнаас нь мулт татахад гарах чимээ)
 - пан/пэн/пин/пон/пөн/пүн (цуурайтай юмны унах/цохих чимээ)
 - таг/тог/түг (хатуу юм цохих чимээ)
 - тан/түн/тон (хатуу юмыг цохих, дэлдэх чимээ)
 - тов (хөнгөн товшлох чимээ)

- ян (төмөр гэх мэт зүйлийг өөр хатуу юмтай харшиж цохиход гарах чихэнд чийртэй чимээ)
- дан/дин/дон/дүн (том хонх гэх мэт жин ихтэй төмөр харшилдах чимээ)
- жин (хундага гэх мэт жижиг нимгэн хөнгөн шил, шаазан, төмөр гэх мэт зүйл харшилдах чимээ)
 - бон/дон (бөмбөг, пүрштэй зүйл ойх чимээ)
 - Юм хатуу олон хэсэгтэй, сагсгар юмыг цохих эсвэл нурах, унах, хагарахад гарах нүргээнтэй чимээ:
 - Тар няр/тор (юм нүргээнтэй унах, нурах чимээ)
 - Пар/пир (хатуу сарчгар юмыг цохиход гарах эсвэл хатуу зүйл шалан дээр унахдаа олон дахин харшиж цохих чимээ)
 - Нар/няр/нүр/нир (олон юм нэг зэрэг дэвслэн хөдлөх эсвэл хатуу юм унах чимээ)
 - Хан (төмөрлөг зэргийн зүйлээс цуурайтан гарах чимээ)
 - Шүргэлцэх, үрэх, хавирахад үүсэх чимээ:
 - хар (хатуу юм унах, хавирах чимээ)
 - тор тор (хатуу жижгэвтэр зүйл унах, хавирах чимээ) гэх мэт байна.
- Эдгээр нь англи хэлэнд хэрхэн илэрч буйг авч үзвэл,
 - Хатуу биет өөр юмтай мөргөлдөх (унах, цохих, нүдэх, дэлсэх, мөргөх гэх мэт):
 - Bonk (хүнд юмаар цохих чимээ)
 - Fa-thad (хүн шалан дээр унаж, ойчих чимээ)
 - Fwww-cluck (хокейн шайб хаалганы тор цохин эргээд мөс цохих чимээ)
 - Penk (хөнгөн цагаан цохиур бейсболын бөмбөг цохих чимээ)
 - Splut (бялуугаар хүний нүүрэнд хүчтэй нялж цохиход гарах чимээ)
 - Thong-thong (агаарын теннисний цохиураар агаарын бөмбөг цохих чимээ)
 - Tuff (төмөр од шидэн бай онох чимээ)
 - Boff/bop/flog (юм цохих, нүдэх чимээ)
 - Bwak/bwok/glok/klok (дэлсэх, цохих эсвэл өшиглөх чимээ)
 - Bong/dong (юм ойж буух чимээ)
 - Clang (төмөр зүйлээр цохин бага зэрэг цуурайтах чимээ)
 - Clank/clink (төмөр харших чимээ)
 - Clap (алгадах, хурц огцом дуутай цохих чимээ)
 - Clash (дуу чимээтэй харшилдах, мөргөлдөх чимээ/хангир жингэр хийх)
 - Ding (төмрөөр цохих чимээ)
 - Jingle (хөнгөн нимгэн төмөр харших чимээ)
 - Pad (хүнд дэвслэн алхах чимээ)
 - Clip clor / klopp klopp (морины алхах чимээ)
 - Tabdak tabdak/ thubalip (морины давхих чимээ)
 - Юм хатуу олон хэсэгтэй, сагсгар юмыг цохих эсвэл нурах, унах, хагарахад гарах нүргээнтэй чимээ:
 - Crash (хагарах бутрах чимээ)
 - Kwok (вааран сав газарт унан хагарх чимээ)
 - Шүргэлцэх, үрэх, хавирахад үүсэх чимээ:
 - Gnash (шүд хавирах чимээ)

- Swishy swashy (өндөр өвсөн дундуур алхахад гарах чимээ) гэх мэтээр дуурайн нэрлэсэн байна.

Монгол хэлний мөргөх, харших утгатай авиа дуурайх үгс голчлон “т/д, п/б” гэх мэт хамжин тэсрэх авиагаар эхлэх боловч хатуу биет өөр зүйлтэй мөргөлдөх бол “с, д, г, н” гэх мэт үе төгсгөх гийгүүлэгчээр төгсч, нурах, хагарах гэх мэтээс үүссэн нүргээнтэй чимээ болон үрэх хавирахаас үүсэх авиаг дуурайсан байвал “р” авиагаар төгссөн байна. Харин англи хэлэнд мөргөх, харших утгатай авиа дуурайх үгс “б, п” гэх мэт дан авиа эсвэл голчлон “кл”, цөөн тохиолдолд “сп, св, бв, кр, кв, гн” гэх мэт давхар гийгүүлэгчээр эхэлсэн үгс байна. Хоёр хэлэнд юм ойх чимээг “бон, дон” гэж мөн хүнд дэвслэн алхах чимээг “пад” гэж нэг ижил буулгасан байна. Бусад үг нь хоорондоо нэлээд зөрөөтэй байна.

4. Хүний дуу хоолой, үйл хөдлөлөөс үүссэн авиа дуурайх үг

Хүний үйл хөдлөлөөс үүсэх дуу чимээг монгол, англи хэлнээ зэрэгцүүлэн үзвэл:

- Найтаах чимээ	- а тшш	- a(t)choo/ah-choo
- Шингэн зүйл залгих чимээ	- гүд гүд	- glug glug
- Лонхоор шингэн юм уух чимээ	- гүд гүд/гүл гүл	- dook dook
- Зүрх цохилох чимээ	- түг түг	- lub-dab lub-dab/dup dup/
- Судас цохилох, лугших	- луг луг/лүг лүг	- throb
- Зажлах чимээ	- хэр хэр/шар шар/шир шир	- crunch crunch
- Үнсэх чимээ	- шов шов	- smack
- Нусаа татах чимээ	- шор	- sniff
- Инээх чимээ	- наг наг/нар нар/ход ход	- whahaha/yuk yuk
- Хоолойгоо зайлах	- гор гор	- gargle/gurgle

Эдгээр дүйлгэсэн жишээг ажиглавал, найтаах, шингэн зүйл залгих, лонхоор шингэн юм уух, хоолой зайлах гэх мэтээс үүсэх авиа дуурайх үгс уг хоёр хэлнээ ойролцоо буюу хагас таарч байхад зүрх цохилох, заглах, нус татах, үнсэх, инээх, цасан дээр гишгэх гэх мэт чимээг дуурайсан үгс огт өөр байна. Харин бүрэн таарч буй жишээ байхгүй байна.

5. Амьтны дуу чимээг дуурайсан авиа дуурайх үг

- Чоно	- арр/ау-уу	- aroo
- Мэлхий	- вааг вааг	- croak/ribbit/brekekekex koax koax
- Царцаа	- цар цар/чар чар	- cricket
- Гахай	- хрр хрр	- oink oink
- Муур	- мяу	- meow/purr/prrr
- Нохой	- хав хав, хов, хон, арр	- bow-wow/woof/ ar roof/arf
- Гөлөг	- гав гав	-
- Хонь	- май	- baa
- Ямаа	- май	- naa
- Үхэр	- мөө, үмбүү	- moo
- Морь	- ийн хохохо	- eeyore/neigh
- Илжиг	- ий оо	- eee-aaah/hee haw
- Хөхөө	- гүүгүүг	- cuckoo

- Хэрээ	- гуаг/гааг/хон хон	- saw
- Галуу	- га га	- quack quack
- Болжмор	- жив жив	- cheep cheep/chirp
- Тагтаа	- гүүг гүүг	- coo
- Шар шувуу	- (г)үү (г)үү	- hoo hoo
- Эм тахиа	- гоог гоог гогоог/го го	- cluck cluck/kut kut kut
- Азарган тахиа	- гугари гүүгүүг (оросоос)	- cock-a-doodle-doo
- Зөгий	- ззззз	- bzzz

Амьтны дуу чимээг дуурайсан үгсийн хувьд муур, үхэр, илжиг, хөхөө, шар шувуу гэх мэт амьтны дуу авиаг дуурайсан үгс бүрэн таарч байна. Харин чоно, нохой, хонь, ямаа, морь, хэрээ, болжмор, тагтаа, зөгий гэх мэт амьтных бүрэн бус буюу хагас төстэй байхад мэлхий, царцаа, гахай, галуу, эм тахиа, азарган тахиа гэх мэт амьтны дуу авиаг дуурайсан үгс нэлээн зөрөөтэй байна.

6. Ахуй амьдралд хэрэглэгдэх эд зүйлээс үүсэх авиаг дуурайх үг

- Хонх дарах чимээ	- дин дон	- ding dong
- Хонхны жингэнэх чимээ	- жин жин	- ching-a-ling
- Том хонх цохих чимээ	- дүн дан	- clang
- Машины сигналын чимээ	- дийд дийд	- beep
- Цагны чимээ	- чаг чаг	- tic toc
- Хайчлах чимээ	- шар шар/шир шир	- snip
- Хаалга тогших чимээ	- тог тог/түг түг	- knock knock
- Галт тэрэгний чимээ	- чиг чиг чиг чиг	- choochoo/chooga

chugga

- Бохь зажлах чимээ	- шаль шаль/жалир жалир	- cham cham
- Зургийн аппаратны товч дарах чимээ	- чиг чиг	- click
- Даашинзны хормойн чимээ	- сэр сэр	- frou frou
- Телефон утасны чимээ	- дpppp	- bringg/brinng

Эдгээр жишээг ажиглаж үзвэл, хаалганы хонхны чимээг яг ижил дуурайн нэрлэсэн байхад, хаалга тогших, галт тэрэг болон хонхны жингэнэх чимээг дуурайсан үгс хагас таарч байна. Харин том хонх, машины сигнал, цаг, хайч, бохь зажлах, зургийн аппаратын товч дарах, даашинзны хормой сэржигнэх, телефон утас дуугарах гэх мэт дуу авиаг дуурайсан үгс хоорондоо нэлээд зөрүүтэй байна.

Эцэст нь дүгнэвэл монгол, англи хэлний авиа дуурайх үгс хоорондоо бүрэн таарах тохиолдол маш ховор, хагас таарч байгаа үгс цөөнгүй хувийг эзэлж байгаа ч хоорондоо огт таарахгүй болон нэлээд зөрөөтэй нэрлэсэн үгс дийлэнх хувийг эзэлж байна. Ихэнх авиа дуурайх үгс монгол, англи хэлнээ ийнхүү зөрөөтэй, өөр байгаа хэдий ч уг хоёр хэлний эдгээр үгсэд орж буй авианууд ижил төстэй байх нь түгээмэл байна.

Аливаа дуу чимээ маш богино хугацаанд дуугараад өнгөрдөг учраас монгол, англи хэлний авиа дуурайх үгс ихэвчлэн товч богино буюу нэг үеэс бүтсэн язгуур үгс байна. Үгийн бүтцийг аваад үзвэл монгол хэлний авиа дуурайх үг ерөнхийдөө ГЭГ гэсэн бүтэцтэй байхад англи хэлнийх ГЭГ, ГГЭГ, ГЭГГ, ГГЭГГ гэх мэтчилэн голдуу

гийгүүлэгч давхарласан бүтэцтэй байхаас гадна зарим тохиолдолд хоёр үеэс бүтэж, мөн урт эгшигтэй хэлэгдэж байна. Харин тухайн дуу авиа давтагдан, үргэлжлэн дуугарах бол үе давтаж хэлэх нь хоёр хэлэнд ижил байна.

Монгол, англи хэлэнд авиа дуурайх үгс ийнхүү ялгаатай байгаагийн шалтгаан нь нэгдүгээрт, тухайн хэлний үг бүтэх онцлогоос хамаарч байна. Тухайлбал, монгол хэл гийгүүлэгч авиа бүрийг эгшгээр амилуулан эгшиг гийгүүлэгчийг сэлгэж хэлдэг байхад, англи хэл нь хатуу буюу нэг дор олон гийгүүлэгчийг хэлж болдог онцлогтой. Хоёрдугаарт, өөр өөр ард түмэн аливаа дуу чимээг сонсож хүртээд, өөрийн хэлнээ ингэж зөрүүтэй тайлан буулгаж байгаа нь тухайн ард аливаа зүйлийг танин мэдэх, түүнийгээ тайлж тайлбарлах ахуй ба сэтгэлгээний онцлогтой нь холбоотой гэж үзэж байна.

НОМЗҮЙ

1. Барайшир Ш. (1970), *Орчин цагийн монгол хэлний дайвар үг*. Улаанбаатар.
2. Базаррагчаа М. (1987), *Монгол хэлний авиа сэлгэх ёс*. Улаанбаатар.
3. Базаррагчаа М. (1995), *Монгол үгийн гарлыг мөшгих нь*. Улаанбаатар.
4. Базаррагчаа М. (2005), *Монгол хэлний өгүүлбэр судлал*. Улаанбаатар.
5. Бямбасан П. (2006), *Монгол хэлний онол, бүтцийн асуудалд*. Улаанбаатар.
6. Дондуков У. Ш, Абашеев Д. А.(1962), *Грамматика бурятского языка*, (Фонетика и морфология). Москва.
7. Лувсанвандан Ш. (1989), *Монгол хэл шинжлэлийн асуудлууд*. Улаанбаатар.
8. Өнөрбаян Ц. (1998), *Орчин цагийн монгол хэлний үг зүй*. Улаанбаатар.
9. Пагва Т. (1987), *Хэл шинжлэлийн удиртгал*. Улаанбаатар.
10. Халтод М. (1973), Олон улсын монголч эрдэмтний II их хурал, II боть, Улаанбаатар.
11. Энхтуяа М. (2002), *Франц-Монгол хэлний авиа дуурайх үгийн зэрэгцүүлэл*. Магистрын зэрэг горилсон бүтээл, Улаанбаатар.
12. <http://www.noisehelp.com/examples-of-onomatopoeia.html>
13. <http://examples.yourdictionary.com/5-examples-of-onomatopoeia.html>

RESUME

In any languages, there are onomatopoeic words, which are words phonetically imitate, resemble or suggest the source of the sound that describe. Although a particular sound is perceived or heard similarly by people of different culture, it is often expressed through use of different sound or consonant strings in various languages. Through this article, we tried to classify onomatopoeic words in Mongolian and English so as to find out what differences and similarities they have by comparing their structure and meaning.